



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



2017 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан

Өвөрхангай аймаг
2017 он

Нэгдүгээр бүлэг.

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд тухай хуулийн дагуу УИХурлын Төсвийн байнгын хорооноос баталсан аудит хийх сэдэв, ҮАГ-ын төлөвлөгөөний дагуу УИХурлын хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх болон төсвийн хөрөнгийн арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор, санхүүгийн болон гүйцэтгэл, нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмжүүд гаргаж, хуульд заасан бусад чиг үүргээ хэрэгжүүлэн, Төрийн аудитын байгууллагын хэмжээнд САХИЛГА ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ жил болгон зарласантай холбогдуулан тус газраас ажилтнуудад ажлын чанарыг сайжруулах шаардлагыг тухай бүрд тавьж, албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулахаар хурууны хээгээр цаг бүртгэх төхөөрөмж байрлуулж, сар бүр цагийн тооцоог хийж, тайлант хугацаанд МУЕАудиторын тушаалаар шинэчлэн баталсан бүтэц, 12 орон тоотойгоор, нийт 12480 хүн цаг ажилласан байна.

Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан төлөвлөгөө, нэгдсэн удирдамжаар гүйцэтгэл, нийцлийн 3 сэдвээр, орон нутгийн ИТХ-ын захиалгаар 2 сэдвээр, санхүүгийн тайлангийн аудитаар бүгд 241 тайланд аудит хийсэн байна.

Тайлант хугацаанд аудитын үр дүнд 355 төрлийн 2134.0 сая төгрөгийн зөрчил илүүлснээс 111 төрлийн 761.6 сая төгрөгийн зөрчил залруулан, 199 төрлийн зөвлөмж өгснөөс 118 төрлийн зөвлөмжийг хэрэгжүүлж, 57 төрлийн 944.0 сая төгрөгийн албан шаардлага өгч 31 төрлийн 270.9 сая төгрөгийн албан шаардлагыг биелүүлж, 15 төрлийн 13.9 сая төгрөгийн төлбөрийн актаас 7 төрлийн 2.7 сая төгрөгийг барагдуулсан байна. Аудитаар тавигдсан төлбөрийн актаас 2.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Байгууллага, аж ахуйн нэгж өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөрөнгөө хэмнэсэн, үр ашгаа дээшлүүлсэн, гарцын чанарыг сайжруулсан бол аудитаас үр өгөөж бий болсон гэж үзэн, аудит хийсэн тухай бүрд үр өгөөж тооцон ажиллаа.


Энэ онд хийсэн аудитаар 1491.5 сая төгрөгийн аудитын үр өгөөжийг бүртгэн тухайн байгууллагуудын удирдлагаар хүлээн зөвшөөрүүлэн, төсвөөс авсан санхүүжилтийн 1 төгрөгийн хариуд 12 төгрөг 85 мөнгөний үр өгөөж бий болгосон байна.

Хоёрдугаар бүлэг.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

2.1 Санхүүгийн тайлангийн аудитаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар ОННТайлан, 19 сумын ТТЗ-ын нэгтгэсэн тайлан, 197 төсвийн шууд захирагч, 26 аж ахуй нэгж, нийт 245 байгууллагын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж, СТАУС програмд 100 хувь гүйцэтгэлтэй байна. нийт 1028.3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 818.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулан, 14 төрлийн 8.3 сая төгрөгийн акт, 39 төрлийн 201.9 сая төгрөгийн албан шаардлага, 172 зөвлөмж хүргүүлсэн байна. Тус аудитаар тайлант онд 65.0 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлсэн байна. Дараах графикаар санхүүгийн тайлангийн аудитын 3 жилийн статистик мэдээг харуулав.



Аудитаар 316 төрлийн 1238.8 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 83 төрлийн 517.6 сая төгрөгийн зөрчлийг залруулсан байна.

Тайлант хугацаанд тавигдсан акт 2.7 сая төгрөг биелэлттэй 5.6 сая төгрөгийн актын хэрэгжих хугацаа болоогүй байна. Албан шаардлага 18 төрлийн 26.9 сая төгрөгийн биелсэн бол нийт 172 төрлийн зөвлөмжийн 110-ыг хэрэгжүүлж 62 зөвлөмж хэрэгжээгүй тул хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн тайланд 0.6 сая төгрөгийн алдааг залруулж, 49.8 сая төгрөгийн албан шаардлага өгч тооцоолсон материаллаг түвшингээс бага байгаа учир “Зөрчилгүй” санал дүгнэлтийг өгсөн байна.

Тайлант онд 46 байгууллагад итгэл үзүүлэн СТАУС програмд тайланг 100 хувь татан оруулсан байна.

Нийт 135 тайланд бие даан дүгнэлт гаргаснаас 129 зөрчилгүй дүгнэлт, 6 хязгаарлалттай дүгнэлт өгсөн байна. Эдгээрт 547.9 сая төгрөгийн алдааг залруулан, 195.8 сая төгрөгийн алдааг залруулаагүй 3 төрлийн 1.7 сая төгрөгийн төлбөрийн акт, 10 төрлийн 19.2 сая төгрөгийн албан шаардлага, 43 төрлийн 174.9 сая төгрөгийн зөвлөмж өгсөн байна.

МУЕА-ын тушаалаар батлагдсан 60 байгууллагын санхүүгийн тайланд түүврийн аргаар аудит хийлээ. Тус аудитаар нийт 83.2 сая төгрөгийн алдааг залруулж, 243.6 сая төгрөгийн алдааг залруулаагүй байна. Орон нутгийн төсөв төвлөрүүлэхээр 6 төрлийн 1.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 9 төрлийн 12.5 сая төгрөгийн албан шаардлага, 40 төрлийн 228.6 сая төгрөгийн



зөвлөмж хүргүүлж, 12.2 сая төгрөгийн үр өгөөжийг тооцон хүлээн зөвшөөрүүлсэн байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/104 дүгээр тушаалаар Төрийн аулитын байгууллагын нэрийн өмнөөс гэрээний үндсэн дээр хувийн аудитын компаниар аудит хийлгэхээр орон нутгийн өмчит 26 аж ахуй нэгжид Дөлгөөнхайрхан-Уул аудит ХХК, Б энд С аудит ХХК-иуд гүйцэтгэж, аудитын явцад 3.4 сая төгрөгийн алдааг залруулан, 18.1 сая төгрөгийн алдааг залруулаагүй байна. Орон нутгийн төсөв төвлөрүүлэхээр 0.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 4 төрлийн 7.8 сая төгрөгийн албан шаардлага, 10 төрлийн 9.8 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлж, 0.4 сая төгрөгийн үр өгөөжийг тооцон хүлээн зөвшөөрүүлсэн байна.

Аймгийн 2016 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар:

Сангийн яамнаас Өвөрхангай аймгийн 2016 оны төсвийн суурь орлогыг 7914.1 сая төгрөгөөр, суурь зарлагыг 20352.1 сая төгрөгөөр, санхүүгийн дэмжлэгийг 12438.0 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийг 41238.7 сая төгрөгөөр, аймгийн ОНХСанд олгох орлогын шилжүүлгийг 4444.6 сая төгрөгөөр хянасан байна.

Аймгийн дүнгээр орон нутгийн төсвийн орлогыг 9805.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 10917.1 сая төгрөг оруулж 111.3 хувиар буюу 1111.6 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ. Орон нутгийн төсөвт орсон нийт татварын орлогын 77.2 хувийг аймгийн төсөвт, 22.8 хувийг сумын төсөвт оруулсан байна.

Аймгийн төсвийн нийт зарлагыг 2016 онд 72970.4 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 70884.4 сая төгрөг зарцуулан, 2086.0 сая төгрөгийн хэмнэлттэй буюу 97.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Өвөрхангай аймгийг төсвийг үндэслэлтэй төлөвлөж орлого нийт дүнгээр давж, төлөвлөсөн зардлыг хэмнэсэн байна. Аудитаар нийт 8 хүн өдөр ажиллаж 0,5 сая төгрөгийн аудитын зардал гарсан байна.

Гуравдугаар бүлэг.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

3.1 Тус аймагт 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, Засгийн газраас олгосон векселийн үр дүнд хийсэн аудитаар:

“Хөрөнгө оруулалтын ТАХ-ний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт, гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.” гэсэн дүгнэлт өгч 3 төрлийн 147.2 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 187.3 сая төгрөгийн үр өгөөж тооцон, холбогдох албан тушаалтнаар хүлээн зөвшөөрүүлсэн байна. Аудитаар нийт 185 хүн өдөр ажиллаж 6.1 сая төгрөгийн аудитын зардал гарсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалт, зарим төсөл арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүй байна. Үүнд:

- Арвайхээр сумын төв замын гэрэлтүүлэг 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, гэрлэн чимэглэл нэмэгдүүлэх ажлын гүйцэтгэгчээр Арвайн эрчим ХХК-ийг шалгаруулж, 79.6 сая төгрөгөөр гүйцэтгэжээ. Өмнө байсан гэрэлтүүлэг нь улайсах гэрэлтэй, хоорондын зай 4 метр зайтай тул солих шаардлагатай гэж үзээд тус бүр 2 туузан гэрэл, 1 ширхэг LED гэрэлтэй 70 ширхэг шонг 3 метр зайтайгаар шинээр суурилуулжээ. Гэрэлтүүлгийн шонг солихгүйгээр LED гэрэл толгойн хамт суурилуулсан бол хамгийн багадаа 40.1 сая төгрөг хэмнэх тооцоо гарч байна.
- Арвайхээр сумын 12, 24, 36, 48, 52 айлын орон сууцууд болон Найрамдал хотхоны байруудын хуучин хаалгыг сольж кодтой төмөр хаалга суулгасан байна. Шинээр хийгдсэн хаалгануудын код эвдэрсэн, зарим хаалга кодыг нь хийсэн ч гаднаасаа онгойхгүй гацдаг байна. Мөн

хаалганы цоожоо гацааж түгжигдэхээргүй болгосон зэргээс харахад оршин суугчдын хүсэл шаардлагад нийцээгүй хаалга суулгасан байна.

- Бүсийн оношилгоо эмчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тоног төхөөрөмж нийлүүлэх тендер шалгаруулалтын техникийн тодорхойлолтыг аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсээс Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлэхдээ БОЭТ-д нэн шаардлагатай коагуляцийн аппарат, наркозын аппарат, судас тодруулагч, тариурын шахуурга зэргийг захиалсан байхад, захиалгад ороогүй гематологи анализатор, пульсоксиметр, интубаци хийх маникен, зүрх судасны хангамжийн үзүүлэн, чиг иж бүрдэл, дамнуурга гэх мэт тоног төхөөрөмжүүдийг бэлтгүүлэхээр захиалсан байна.

Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

Улсын төсөв:

БСШУСЯ-аас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд 376.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг тус аймгийн сургууль цэцэрлэгүүдэд хуваарилсан хуваарийг аймгийн БСУГ-т ирүүлсэн байна. Гэтэл хуваарилагдсан тоног төхөөрөмжөөс нийт 9 цэцэрлэг, 1 ЕБС-д бүгд 26.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж ирээгүй байхад БСУГ хэрэгжилтэд хяналт тавиагүй байна.

Орон нутгийн төсөв:

Сүвэн-Уул ХХК нь БОЭТ, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тоног төхөөрөмж нийлүүлэх тендер болон гэрээнд заасан үзүүлэлтийг хангаагүй тоног төхөөрөмжийг БОЭТ-д нийлүүлсэн байхад гэрээтэй тулгаж үзээгүй, комисст гэрээ байгуулсан ажилтан оролцоогүй, хүлээж авсан байна.

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Гэрээгээр нийлүүлэх тоног төхөөрөмжийн үзүүлэлт	Сүвэн-Уул ХХК-ийн нийлүүлсэн тоног төхөөрөмжийн үзүүлэлт
1	Монитор	1. Бичлэг 6 ЭКГ-2, SpO2, RR, EtCO2, IBP-2 бичлэгийн хурд 6.25, 12.5, 25, 50 mm/sek 2. Хүчилтөрөгчийн гаралт хэмжигчтэй 3. 12 сувагтай электро кардиограф хэмжих горимтой. 4. Дохионы 3 түвшинтэй, мэдээлэгч гэрлийн ламп 5. Дахин цэнэглэдэг цэнэгээ барьдаг батарейтай байх. 6. Мэдрэгчтэй дэлгэцтэй, эргэдэг кноптой.	1. Бичлэг 6 ЭКГ-2, SpO2, RR, бичлэгийн хурд 6.25, 12.5, 25, 50 mm/sek 2. Дохионы 3 түвшинтэй, мэдээлэгч гэрлийн ламп 3. Дахин цэнэглэдэг цэнэгээ барьдаг батарейтай байх.
2	Хагалгааны багаж /эмэгтэйчүүд/	Гинекологийн хагалгааны иж бүрэн багаж хэрэгсэл /нэр төрөл 42-с дээш/	Гинекологийн хагалгааны иж бүрэн багаж хэрэгсэл /нэр төрөл 26 нэр төрлийн 43 ширхэг/
3	Шээсний шинжилгээний аппарат	1. 15-16 үзүүлэлтэй, тунадас хардаг 2. Бүрэн автомат 3. Тог баригчтай	1. 15-16 үзүүлэлтэй, тунадас хардаггүй 2. Хагас автомат 3. Тог баригчгүй
4	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч	1. Цахилгаан тэжээл 220В, 50Гц 1Тз 2. Хүчилтөрөгчийн концентранци 95,5-85% 3. Хүчилтөрөгчийн урсгал 1-5л/мин 4. Гарах даралт 0,04-0,05МПа	1. Цахилгаан тэжээл 220В, 50Гц 1Тз 2. Хүчилтөрөгчийн концентранци 95,5-85% 3. Хүчилтөрөгчийн урсгал 1-5л/мин
5	Ходоодны видео дуран	Fujinon 2200 маркийн процессорт тохирох /ходоодны дурангийн марк EG250 WL 5/	Fujinon 2200 маркийн XENON ламп

6	Гематологи анализатор	1. Бүрэн автомат 2. 20 үзүүлэлтэй 3. тог баригчтай байх	1. Хагас автомат 2. 20 үзүүлэлтэй 3. тог баригчтай байх
---	--------------------------	---	---

Дөрөвдүгээр бүлэг.

НИЙЦЛИЙН АУДИТ

Нийцлийн аудитаар Орон нутгийг хөгжүүлэх сангийн зарцуулалт, үр дүнд аудит хийж, Өвөрхангай аймагт 2013-2014 онд Идлэг шонхор шувуу барих, гадаад оронд гаргах үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудитыг 2 асуудлын хүрээнд бичил тайлан бичиж судалгааны хамт ҮАГ-т хүргүүлсэн байна. Тус аудитуудаар давхардсан тоогоор 51 байгууллага, 34 сумдыг хамрагдаж, 17 төрлийн 729.5 сая төгрөгийн албан шаардлага, 9 төрлийн зөвлөмжийг өгч хэрэгжих хугацаа болоогүй байна. Аудитаар 729.5 сая төгрөгийн үр өгөөж тооцон, хүлээн зөвшөөрүүлсэн байна.

4.1 Орон нутгийг хөгжүүлэх сангийн зарцуулалт, үр дүнд хийсэн аудитаар:

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу зохион байгуулсан ч сангийн хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, дотоод хяналт хангалтгүй байна гэсэн дүгнэлт өгч аудитаар 729.5 сая төгрөгийн үр өгөөж тооцож, 17 төрлийн 729.5 сая төгрөгийн албан шаардлагыг аймаг, сумдад хүргүүлж хэрэгжих шатандаа байна.

Аудитаар ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд дараах зөрчил гарсан байна. Үүнд:

1. Зориулалт бусаар зарцуулсан төсөл, арга хэмжээ:

- Баруунбаян-Улаан, Тарат, Есөнзүйл, Уянга, Хархорин сумд гамшгаас хамгаалах зардалд 2.6-6.9 сая төгрөг,
- Бат-Өлзий сум гэрэлтүүлгийн урсгал засварын ажлын цалин хөлсөнд 3.4 сая төгрөг,
- Уянга сум хог зайлуултанд 30.0 сая төгрөг, Уянга, Хархорин сумд нохой устгахад 3.7-6.0 сая төгрөг,
- Хархорин, Төгрөг сумд Залуучуудыг дэмжих жилд 5.0 сая төгрөг,
- Хужирт сум Цагдаагийн цахим торгуулийн машин авахад 4.1 сая төгрөг,
- Зүүнбаян-Улаан сумын урт хугацааны “2014-2024 онд хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр” номыг 3.0 сая төгрөгөөр хэвлүүлсэн зэрэг нийтдээ 14 төсөл арга хэмжээнд 79.1 сая төгрөгийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсанд албан шаардлага өгч байна.

2. Дутуу буюу чанаргүй хийгдсэн, хугацаа хэтэрсэн төсөл арга хэмжээ:

- Бүрд сумын Сургуулийн спорт заалны засварын 57.9 сая төгрөгийн ажил агааржуулалт хийгдээгүйгээс ханын шохой хууларсан,
- Хужирт сумын 2-р Цэцэрлэгийн агааржуулалтын 5.7 сая төгрөгийн ажлын дулаалга муу хийгдсэнээс мөстөлт үүсэж сэнс нь ажиллахгүйгээс хана таазанд хөгц цохисон,
- Өлзийт сумын Бор хошууны багийн хөгжлийн төвийг 49.7 сая төгрөгөөр шинээр барьж, халаалтыг цахилгаан халаагуураар шийдсэн ч разетка цөөн хийгдсэнээс ачааллаа даахгүй, халахгүй байгаа, ЭМТөвийн 9.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж зах зээлийн үнээс өндөр, чанар хангалтгүй,

Зураг 1: Бүрдний спорт заалны барилга чанаргүй баригдсан байна



- Есөнзүйл сумын СӨББ-ын 5.0 сая төгрөгийн вакум цонхыг хуучин модон рам дээр суулгаснаас салхи сийгдэг,
- Гучин-Ус сумын 5.9 сая төгрөгийн хадлангийн газар хашаалах материал худалдан авах ажил, ашиглагдахгүй байгаа гар худгийг сэргээн засварлах 7.8 сая төгрөгийн ажил, усалгаатай газар тариалангийн 24.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн ажил, мал ариутгалын 16.5 сая төгрөгийн машин авах ажлууд бүрэн дуусаж хүлээн аваагүй,
- Арвайхээр сумын Ногоон байгууламж бүхий спорт, тоглоомын талбай байгуулах ажлаас сагсны шийд эвдэрсэн, талбайн өнгөлгөөтэй бетон тоосгоны орох хаалганы зүүн тал нурсан, зүлэгжүүлэлт, мод суулгалт бүрэн хийгдээгүй, амрах сандал 5, хогийн сав 2 дутуу, орох гарах хаалгыг эргэлддэг хаалгаар солих, сувгийн дээр сараалж, шүүр тавих, усан оргилуурын бетон шал цутгах ажлууд хийгдээгүй, явган хүний замын хучилт үерийн усанд идэгдэж урссан, 4 гэрэлтүүлэг хийгдээгүй зэрэг нийтдээ 8.4 сая төгрөгийн ажил дутуу буюу чанаргүй хийгдсэн,
- Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр Арвайхээр суманд баригдаж байгаа 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын явц 60.0 хувьтай байгаа ба үлдэх 40.0 хувь буюу 340.6 сая төгрөгийн ажил гэрээт хугацаандаа дуусаагүй зэрэг нийтдээ 11 төсөл арга хэмжээний 531.6 сая төгрөгийн ажил дутуу буюу чанаргүй хийгдсэн, хугацаа хэтэрсэнд албан шаардлага өгч байна.

Зураг 3: Арвайхээр сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн ажил хугацаандаа дуусаагүй байна.



3. Хэрэгжээгүй, санхүүжилтээ аваад ажлаа хийгээгүй төсөл арга хэмжээ:

- Уянга сумын Соёлын төвийн гадна талын тохижилтод 16.2 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн ч ажил хийгдээгүй,
- Хужирт сумын Үерийн далан засварлах 5.0 сая төгрөгийн ажил,
- Сант сумын Орон нутгийн өмчийн орон сууцыг төвлөрсөн халаалтад холбох 17.4 сая төгрөгийн ажил, Үйлчилгээний төвийг цэвэр бохирт холбох 3.7 сая төгрөгийн ажил зэрэг нийтдээ 4 төсөл арга хэмжээний 42.3 сая төгрөгийн ажил хийгдээгүйд албан шаардлага өгөгдөж байна.

Аудитаар нийтдээ 34 төсөл арга хэмжээтэй холбоотой 729.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага тавигдсан болно.

График 1: Өвөрхангай аймгийн 2016 оны ОНХС-ийн аудитаар илэрсэн зөрчлийн төрлөөр

/сая төгрөг/



4.2 Өвөрхангай аймагт 2013-2014 онд Идлэг шонхор шувуу барих, гадаад оронд гаргах үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудитаар:

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.2-д ахуйн, үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнасан бусад ан амьтны төлбөрийг тухайн ан амьтны толгой тутмын экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40 хувиар гэж заасны дагуу ЗГ-ын 2011 оны 01 дүгээр сарын 25-ны №23 тогтоолоор “Үнэлгээ, төлбөр, хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” шийдвэрээр ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг идлэг шонхор шувууг 16000.0 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Үүнийг үндэслэн Өлзийт сум 1 идлэг шонхрын экологи эдийн засгийн үнэлгээний 40.0 хувь болох 6400.0 мянган төгрөгийн төлбөрийн орлогыг сумын төсвийн орлогын дансанд, Есөнзүйл сум 4 идлэг шонхрын экологи эдийн засгийн үнэлгээний 40.0 хувь болох 25600.0 мянган төгрөгийн төлбөрийн орлогыг сумын төсвийн орлогын дансанд тус тус оруулсан байна.

Харин өгөөшийн төлбөрөөр орон нутгийн төсвийн орлогын дансанд орлого ороогүй болно. Өгөөш болох тагтаа шувууг барьсан талаар баримт, мэдээ байхгүй байна.

Аймгийн Татварын хэлтсээс Шонхор шувууны агнуурын нөөцийн төлбөрт төлсөн орлогын бүрдүүлэлт судалгааг авч үзэхэд дээрх сумдуудад оруулсан төлбөрийн орлогын дүнтэй тохирч байсан.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд зааснаар нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 50 хувиар тогтоосныг үндэслэн Есөнзүйл сумын ИТХТ-ийн 2014 оны 10 дугаар сарын 24-ны №19 тогтоолоор орон нутгийн төсөвт ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого /шонхор шувуу/ 25600.0 мянган төгрөг оруулсны 50.0 хувь буюу 12800.0 мянган төгрөгийг Байгаль хамгаалах санд шилжүүлэхээр тогтоож, байгаль хамгаалах сангаас 2014 онд БОХУБайцаагчийн албан хэрэгцээнд 5534.9 мянган төгрөг, 2015 онд 3600.0 мянган төгрөгийг мод тарих, байгаль орчныг нөхөн сэргээхэд зарцуулахаар шийдвэрлэн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Орон нутагт Идлэг шонхор шувуу экспортын зориулалтаар барихад холбогдох төр, захиргааны байгууллагуудын хяналт хангалтгүй байжээ.

Тавдугаар бүлэг.

**ИТХ-ЫН ХҮСЭЛТЭЭР БОЛОН ӨӨРИЙН
САНААЧЛАГААР:**

5.1 Өмчийн хэлтсээс 2013-2016 оны хооронд зохион байгуулсан дуудлага худалдаа, оролцогчдын хураамжийн зарцуулалтын үр дүнд хийсэн аудитаар:

Дуудлагын худалдааг журмын дагуу зохион байгуулж байгаа ч бэлтгэл ажил хангалтгүй, худалдсан хөрөнгийн орлогыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлээгүй, оролцогчдын хураамжийг үрэлгэн зарцуулсан байна гэсэн дүгнэлт өгч аудитаар 25.0 сая төгрөгийн үр өгөөж тооцож, 12.6 сая төгрөгийн албан шаардлага өгч, 5.6 сая төгрөгийн акт тогтоосон хэрэгжих шатандаа байна. Аудитаар нийт 185 хүн өдөр ажиллаж 6.1 сая төгрөгийн аудитын зардал гарсан байна.

Дуудлагын худалдааг 2013 онд зохион байгуулсан аймгийн ЗДТГ-т бүртгэлтэй Хангамжийн 24 айлын орон сууцны 2-14 тоотын 3 өрөө, 12 айлын орон сууцны 1-6 тоотын 3 өрөө байрны худалдах доод үнийг 38.0 сая төгрөг болон 43.0 сая төгрөгөөр тогтоосон байхад оролцогчийн хураамжийг 5 хувиар бус тус бүр 0.5 сая төгрөгөөр, бусад хөрөнгийн хувьд 5 хувиар тооцож авсан байна.

Аудитад хамрагдсан тайлант онуудад дуудлагын худалдаанд оролцогчдын хураамжаас нийт 20.9 сая төгрөг төвлөрсний 6.5 хувийг зар сурталчилгааны төлбөрт, 6,6 хувийг үнэлгээ хийлгэсний хөлсөнд, 4.7 хувийг бичиг хэрэг, шуудан холбооны зардалд, 46.8 хувийг шатахуун, сэлбэг хэрэгслийн зардалд, 26,6 хувийг хоол хүнс, архи дарс, чихэр жимс худалдан авахад, 8.8 хувийг бусад зардалд зарцуулжээ.

Д/д	Зардлын нэр төрөл	Зардлын дүн /мянган төгрөгөөр/				
		2013 он	2014 он	2015 он	2016 он	Бүгд
1	Зар сурталчилгааны төлбөр	-	333.7	531.1	504.0	1,368.8
2	Үнэлгээний зардал	-	320.0	150.0	920.0	1,390.0
3	Бичиг хэрэг, шуудан холбооны зардал	-	99.8	876.9		976.7
4	Шатахуун, сэлбэг хэрэгслийн зардал	2,101.5	6,258.8	1,218.0	225.0	9,803.3
5	Хоол хүнс, архи, ундаа, чихэр худалдан авахад	1,338.5	2,889.7	714.0	622.9	5,565.1
6	Бусад зардал	580.0	662.0	287.8	312.5	1,842.3
	Нийт зардал	4,020.0	10,564.0	3,777.8	2,584.4	20,946.2

Дуудлагын худалдааны хураамжийн орлого, зарлагад бэлэн мөнгөний гүйлгээний тайлангаас өөр бүртгэл хөтлөгдөхгүй, гүйлгээг санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгахгүй, зөвхөн хэлтсийн даргын мэдлийн хүрээнд зарцуулагдаж ирсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийг зөрчсөн байна.

Зургаадугаар бүлэг.

БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЖЛЫН ТАЛААР:

Тайлангийн хугацаанд тус газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын 40 тушаал гаргаж, явсан бичиг 87, ирсэн бичиг 171 бүртгэж, хариутай 21 албан бичгийг хугацаанд шийдвэрлэж ажилласан байна. Мөн ҮАГ-аас дотоод сүлжээгээр танилцуулагдсан мэдээ, мэдээлэл, сургалтад тогтмол амжилттай оролцон үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр хангаж ажиллаж ирлээ.

Өөрийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгож мэдээллийн самбарт үндсэн ажлын чиг үүрэг хийсэн ажлын товч тайлан, төсвийн зарцуулалтын мэдээ, шалгадагч байгууллагын талаарх мэдээлэл, санхүүгийн тайлангийн аудит хийх хуваарь зэрэг холбогдох мэдээллийг тухай бүр шинэчлэн тавьж ил тод байдлыг ханган ажиллаж хэвшээд байна. Байгууллагын вэйб сайт <http://www.audit.ov.gov.mn/>-д засвар хийж ашиглалтад оруулан, тухайн онд хийсэн аудитууд, акт, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийг ил тод нээлттэй байдлаар тавьж, хэвшээд байна. Мөн ҮАГ-ын нэгдсэн сайт <http://www.audit.mn/>, өөрийн орон нутгийн, <https://www.facebook.com/uvurkhangai.audit> сайтуудад аудитын шалгалтын дүнгийн талаарх товч тайлан, цаг үеийн мэдээллүүдийг тогтмол тавьж ирснээр нийт хандалтын тоо 1465 хүнд хүрч өссөөр байна.

Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны 3 өдрийн уулзалт зөвлөгөөнд дарга бөгөөд тэргүүлэх аудитор, аудитын менежер нар амжилттай оролцсон байна. Хууль зүй, дотоод хэргийн

яамнаас орон нутгийн төрийн албан хаагчдыг чадавхжуулах "Захиргааны ерөнхий хууль"-ийн сургалтад 3 албан хаагч хамрагдсан. Мөн нэгдсэн удирдамжаар хийгдэж буй аудит болон бусад дотоод ажлын хүрээнд ҮАГ-аас онлайнаар зохион байгуулсан 6 удаагийн мэдээлэлд 11 албан хаагч бүрэн хамрагдаж, СТАУС 2 програм ашиглан санхүүгийн тайлангийн аудитыг хэрхэн хийх талаар сургалтыг ҮАГ-ын ахлах аудитор Ж.Батсайханыг аймагтаа урьж Баянхонгор аймгийн аудитын газрын албан хаагчдын хамт сургалт зохион байгуулан уг сургалтанд 11 ажилтан хамрагдсан, санхүүгийн тайлангийн аудитаар нийтлэг гарч буй зөрчил 2017 оны аудитаар юунд анхаарах талаар сургалт ахлах аудитор Ж.Нямаа албан хаагчдад сургалт хийлээ нийт **146 хүн цаг суралцсан** байна.

Өвөрхангай аймгийн Засаг даргын санаачилсан Санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх зөвлөгөөн зохион байгуулахад тус газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор орон нутгийн төсөвт байгууллагын нийтлэг гарч буй зөрчлийн талаар урилгаар илтгэл тавьж зөрчилтэй дүгнэлт авсан албан тушаалтанд хариуцлага тооцох, санал хүргүүлж төрийн аудитын байгууллага санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэхийг уриалсан байна.

Ажилтнуудаас хувийн ашиг сонирхолын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахимаар болон цаасаар хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулсан мөн аудит хийх тухай бүр ашиг сонирхолгүйн зөрчилгүй мэдэгдлийг гаргуулсан байна.

Тайланд оны эхэнд 11 ажилтнаас нууцын баталгаа гаргуулан авч, төрийн нууцад хамаарах Зэвсэгт хүний ангиудын санхүүгийн тайланг нууцын ажилтнаар дамжуулан хүлээн авч холбогдох аудиторууд аудит хийж, материалыг нууцын ажилтан нууцын архивт хадгалан тухай байгууллагад аудитлагдсан тайланг хүргүүлсэн байна.

Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажлын стресс тайлах, өвлийн улиралд ханиад томуунаас урьдчилан сэргийлж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор санхүүгийн тайлангийн аудитын ачаалал ихтэй 1-4 дүгээр саруудад ВИТАМИНЖУУЛАХ аян зохион байгуулан, өдөр бүр халуун чацаргана, олон төрлийн витаминаар үйлчилгээ үзүүлэн 0.3 сая төгрөгийг албан хаагчдын бие эрүүл мэндэд зориулан зарцуулсан байна.

Мөн хамт олны санаачлагаар "Хамт олны хуримтлалын сан"-г бий болгон өнгөрсөн жилээс эхлэн сар бүр 10-30 мянган төгрөгийг цалингаас суутгуулан, тодорхой хэмжээний мөнгөн хуримтлалтай болсон нь төсвөөс мөнгө зарцуулахгүйгээр албан хаагчдын гачигдал зовлон, зарим нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байна.

Долоодугаар бүлэг.

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ:

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг ННБ-ын тухай хуулийн дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлэн, төрийн өмчийн бүртгэл програмд хөрөнгийн бүртгэлийг бүрэн баталгаажуулан, хууль тогтоомжийн дагуу удирдан зохион байгуулж, төсвийн ил тод байдал, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлж эхний хагас жилийн байдлаар шилэн дансны цахим хуудаст 68 удаагийн мэдээлэл байршуулсан байна. Тайланд хугацаанд 116,5 сая төгрөгийн төсвийн санхүүжилт авч 116,1 сая төгрөгийн төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 439 дүгээр "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллого явуулах тухай" тогтоол, Сангийн сайдын 2016 оны 126 дугаар "Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого явуулах журам" тушаалын дагуу хагас жилийн өмч хөрөнгийн тооллого явуулж 102.7 сая төгрөгийн хөрөнгө тоолж ашиглах боломжгүй болсон 11.7 сая төгрөгийн хөрөнгийг актлах данснаас хасах санал ҮАГ-газарт хүргүүлсэн байна.